



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 23 өдөр

Дугаар 456

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалт, Говь-Алтай аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Хилийн ажилчдын байр болох нийт 800,000,000.00 (найман зуун сая) төгрөгийн балансын үнэ, 37,777,777.74 (гучин долоон сая долоон зуун далан долоон мянга долоон зуун далан долоон төгрөг далан дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч, Говь-Алтай аймгийн Бургастай дахь Гаалийн хорооны балансад бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.


3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР


Б.ГАВАА



0002220



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2018 оны 10 дугаар сарын 28-ний өдрийн  
 486... дугаар тогтоолын хавсралт



Говь-Алтай аймгийн Бургастай дахь Гаалийн хороонд  
 бүртгэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Хилийн ажилчдын байр	2015/12/29	800,000,000.00	37,777,777.74	762,222,222.26
	Дүн		800,000,000.00 (найман зуун сая)	37,777,777.74 (гучин долоон сая долоон зуун далан долоон мянга долоон зуун далан долоон төгрөг далан дөрвөн мөнгө)	762,222,222.26 (долоон зуун жаран хоёр сая хоёр зуун хорин хоёр мянга хоёр зуун хорин хоёр төгрөг хорин зургаан мөнгө)